

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд:

“ХҮІ.7. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

7.1. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай монголын талын эзэмших хувьд ногдох хөрөнгийн санхүүжилтийг судалж 2018 оны улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгав.

7.2. Ангарын барилга, агаарын хөлгийн явгалах зам, зогсоол, дэд бүтцийн шугам сүлжээ, газар шорооны ажил болон зураг төслийг “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал төсөл”-ийн зээлийн үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлыг судлан зохих журмын дагуу шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат нарт даалгав.

7.3. “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын менежемент төсөл”-ийг хэрэгжүүлэх компанийн монголын болон японы талуудын эзэмших хувь, Монголын талын эзэмших хувьд оролцох этгээдийн эзэмших хувь хэмжээг тус тус тодорхойлж, саналаа Засгийн газарт танилцуулахыг Ерөнхий сайдын 2017 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн дарга бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт даалгав.

7.4. Агаарын хөлгийн шатахуун хангамжийн гидрант системийн үйл ажиллагааны схемийг тодорхойлж, шатахуун хангамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг судалж шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт даалгав.

7.5. Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий катерингийн барилгыг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д “барих-ашиглах-шилжүүлэх” нөхцөлөөр гүйцэтгүүлэх асуудлыг судлан боловсруулж, Засгийн газарт оруулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгав.

7.6. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлыг барих Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагаа, төслийн зээлийн захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үр дүн, дүгнэлт, саналаа 2017 оны 10 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт

